ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 23 өдөр | Дугаар 10/01 | Эрдэнэт

"Эрдэнэт үйлдвэрлэл" дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдалгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", 19 дүгээр зүйлийн 19.1, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжих "Эрдэнэт үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтын тус тус баталсугай.

2."Эрдэнэт үйлдвэрлэл" дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах зардлыг тухайн оны орон нутгийн төсөвт тусган, биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100234